

БАЯНХОНГОР АЙМАГ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

Огноо:2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ НОРМЫН ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ
НОРМЫН ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ

Тендер шалгаруулалтын дугаар: БХАНЭ/ 2020005

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос нормын хувцас, зөөлөн эдлэл бэлтгэн нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэ урилгад заагдаагүй бусад нөхцлийг тендерийн баримт бичигт тусгасан болно.

Үнийн саналыг *2020 оны 05 дугаар сарын 08-ны 11 цаг 00 минутаас өмнө [Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүү]* хаягаар ирүүлнэ.

Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05 дугаар сарын 08**-ны өдрийн **11 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг Амбулаторийн 2 давхар № 213 тоот өрөө

Холбоо барих утас: 99078900, 88407911

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1.Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 1.2.Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
- 1.2. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 1.3. Тендерийн иж бүрдэл**
- 1.3. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) Үнийн санал; Ирүүлэх
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; Ирүүлэх
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг Ирүүлэх
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 2. Тогтмол үнэ**
- 2.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 3. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 3.1. Нийлүүлэх бараа нь энд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд үүнийг заавал мэдэгдэнэ.
- 3.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг батлах үүрэгтэй.
- 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 5 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

5. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

- 5.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 5.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **нэг** багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 5.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

6. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 6.1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2018, 2019] жилийн санхүүгийн тайлан ирүүлэх Сүүлийн [2018, 2019] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <ul style="list-style-type: none"> ➤ Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь: Ирүүлэх ➤ Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар: Ирүүлэх ➤ Татварын байгууллагын тодорхойлолт /өргүй байх/ цахим тайлангаас: Ирүүлэх ➤ Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2019 он ➤ Борлуулалтын орлого: 10 сая төгрөгөөс багагүй байна./Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлангаас/ ➤ Урьдчилгаа санхүүжилт авахгүй эсэхээ албан бичгээр мэдэгдэх ➤ Нийлүүлэх барааны танилцуулга, фото зураг ирүүлэх ➤ Нийлүүлэх хуваарийн дагуу байх ➤ Нийлүүлэгч тухайн барааг өөрийн зардалаар хүргэн ирж хүлээлгэн өгнө. <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:<i>Шаардлагагүй</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа : <i>Нэгдсэн эмнэлэг Амбулаторийн 2 давхар №201 тоот өрөө 2020 оны 05 дугаар сарын 08-ны 11 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Баянхонгор аймаг Амбулаторын 2 давхар №213 тоот өрөө Огноо: 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр. Цаг: 11 цаг 30 минутад</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт нормын хувцас, зөөлөн эдлэл бэлтгэн нийлүүлэх үнийн санал авах тендерийн баримт бичиг БХАНЭ/ 2020005 1 багц: Цагаан хэрэглэл, даавуу</p>

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д , эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **ажлын 5** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

цуцлах

- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Тав. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1 [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1 Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан падан, нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.0 Баталгаат засварын тусгай шаардлага
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)** Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- 7.1 Гэрээний үнийн дүнгийн **[100]¹** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 11)²** 11.1 Алданги оногдуулах хувь: **0,5%**
Алдангийн нийт дүн: **10%**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг еерчилнэ.

Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт:

- Нийлүүлэгч нь тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг өөрийн оёдлын цех, нэгжтэй байна.

Зургаа. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
1.Барааны тодорхойлолт, нийлүүлэх хуваарь:

1 багц:

Цагаан хэрэглэл

д/д	Нэр	Барааны тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Ор, хөнжлийн даавуу / Ор, хөнжил, дэрний уут /	100% хөвөн даавуун материалтай, цагаан өнгөтэй, тууш судалтай, угааж халдваргүйтгэхэд агшдаггүй, өнгөө алддагүй материал бүхий 3 хос байна. Хөнжлийн даавууны урт 210 см өргөн 150 см, Дэвсгэр даавууны урт 220 см өргөн 160 см дэрний уут 45*65 см	ш	200
2	Гудас	Эмнэлэгийн зориулалтын орны гудас нь 45%-иас ихгүй полистер, 55 %-иас багагүй хөвөн даавуун материалтай PH4.8-7.5 байна. Будгийн 3-4 болон түүнээс дээш, агшилт суналт нь +- 2, Формальпегид-75, цайвар өнгөтэй, хэтэрхий эрээн биш угааж халдваргүйтгэхэд боломжтой зузаан нь 3 см -ээс багагүй байна. Урт нь 2 м-ээс багагүй өргөн нь 85 см -ээс багагүй байна.	ш	100
3	Хөнжил	Хөнжлийн урт 210 см -ээс багагүй, өргөн 160 см-ээс багагүй, зузаан нь 5 см-ээс багагүй, гадар нь хөвөн даавуун материалаар хийгдсэн, хурц тод өнгөтэй биш цайвар өнгөтэй, угааж халдваргүйтгэхэд хялбар, угаалгын машинаар угаах боломжтой, зулхай биш байх	ш	120
4	Дэр	Дэр нь 45*65 см ээс багагүй. Угааж халдваргүйтгэхэд трхиромжтой материал бүхий байна. Дотроо даавууны өөдөс агуулаагүй, өдөн биш байна.	ш	200

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

1. Стандарт: *Олон улсын стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.*
2. Бараа хүргэх газар: [Баянхонгор аймаг Нэгдсэн эмнэлгийн агуулах]
3. Бараа нийлүүлэлтийн хуваарь: Бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу

1. Бараа нийлүүлэх хуваарь

1 багц:

Цагаан хэрэглэл

№	Барааны нэр	Чанар, стандарт, хэмжээ	Тоо хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Ор, хөнжлийн даавуу / Ор, хөнжил, дэрний уут /	100% хөвөн даавуун материалтай, цагаан өнгөтэй, тууш судалтай, угааж халдваргүйтгэхэд агшдаггүй, өнгөө алддаггүй материал бүхий 3 хос байна. Хөнжлийн даавууны урт 210 см өргөн 150 см, Дэвсгэр даавууны урт 220 см өргөн 160 см дэрний уут 45*65 см	200	Гэрээ байгуулсан өдрөөс хойш
2	Гудас	Эмнэлэгийн зориулалтын орны гудас нь 45%-иас ихгүй полистер, 55 %-иас багагүй хөвөн даавуун материалтай PH4.8-7.5 байна. Будгийн 3-4 болон түүнээс дээш, агшилт суналт нь +- 2, Формальпегид-75, цайвар өнгөтэй, хэтэрхий эрээн биш угааж халдваргүйтгэхэд боломжтой зузаан нь 3 см -ээс багагүй байна. Урт нь 2 м-ээс багагүй өргөн нь 85 см -ээс багагүй байна.	100	Гэрээ байгуулсан өдрөөс хойш
3	Хөнжил	Хөнжлийн урт 210 см -ээс багагүй, өргөн 160 см-ээс багагүй, зузаан нь 5 см-ээс багагүй, гадар нь хөвөн даавуун материалаар хийгдсэн, хурц тод өнгөтэй биш цайвар өнгөтэй, угааж халдваргүйтгэхэд хялбар, угаалгын машинаар угаах боломжтой, зулхай биш байх	120	Гэрээ байгуулсан өдрөөс хойш
4	Дэр	Дэр нь 45*65 см ээс багагүй. Угааж халдваргүйтгэхэд трхиромжтой материал бүхий байна. Дотроо даавууны өөдөс агуулаагүй, өдөн биш байна.	200	Гэрээ байгуулсан өдрөөс хойш

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ (Тамга, тэмдэг)	_____
_____	_____
ДАРГА. (Гарын үсэг)	_____
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН НОРМЫН ХУВЦАС ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ.**

Дугаар №

2020 оны ... сарын ... өдөр

Баянхонгор хот

Нэг “” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас

[захиалагчийн нэр]

“.....” (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож

[нийлүүлэгчийн нэр]

2020.. оны .. сарын ... -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт нормын хувцас зөөлөн эдлэл бэлтгэн нийлүүлэх” гэрээ-ний (цаашид “бараа” гэх) төгрөг /..... төгрөг/ (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь нэр төрлийн барааг 2020.. оны ... дугаар сарын ...-нөөс 2020... оны дугаар сарын -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцэлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.
9. Гэрээний хугацаанд нийлүүлэх бараа, материалын үнэ тогтмол байна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

